



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/56/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn Аудитор: Л.Энх-Амгалан Утас: 325093 Цахим хаяг: enkhambalanl@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

нэг.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 02. 23 № 34

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ
ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА, ТӨСВИЙН
ШУУД ЗАХИРАГЧ Л.БАТБАЯР
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Баянгол дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад нэмэлт санхүүжилтийн орлогоор худалдаж авсан бараа материалыг эд хариуцагчаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэснээс бусад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой онцлог асуудлуудыг нэгтгэн харуулав. Үүнд:

Тус байгууллагад Соната болон Старикс маркийн суудлын 2 автомашин бүртгэлтэй байна.

Зөвлөл, хороо комиссын гишүүдийн ажлын хөлс, өрхийн судалгааны зардлын санхүүжилтүүд нэмэлт санхүүжилтийн дансаар дамжиж зарцуулагдсан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус хэлтсийн

002021679

талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлд тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий удирдлагын шийдвэр, ажил гүйлгээ, үйл явдал үүсээгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

D:\Desktop\2024\Word\Резан Баян\2024.02.21.BSD.HHJ.H.docx

Хоёр.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>21,713,855.00</u>	<u>13,072,646.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	21,713,855.00	13,072,646.00
354	Хангамжийн материал	21,713,855.00	13,072,646.00
35410	Бичиг хэргийн материал	7,287,500.00	6,238,850.00
35420	Аж ахуйн материал	14,110,439.00	6,540,900.00
35470	Бусад хангамжийн материал	315,916.00	292,896.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,169,420,118.99</u>	<u>1,122,883,242.93</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,169,420,118.99	1,122,883,242.93
392	Биет хөрөнгө	1,146,252,498.91	1,101,015,622.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,199,709,672.00	1,199,709,672.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-123,668,698.20	-151,947,107.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	83,915,000.00	83,915,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-83,915,000.00	-83,915,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	106,065,958.00	106,065,958.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-81,743,746.47	-88,501,292.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	127,433,129.00	127,433,129.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-81,543,815.42	-91,744,735.76
393	Биет бус хөрөнгө	23,167,620.08	21,867,620.12
39301	Программ хангамж	8,076,900.00	8,076,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,337,279.92	-5,637,279.88
39303	Бусад биет бус хөрөнгө	19,428,000.00	19,428,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,191,133,973.99</u>	<u>1,135,955,888.93</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,191,133,973.99</u>	<u>1,135,955,888.93</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,191,133,973.99	1,135,955,888.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	497,040,067.31	497,040,067.31
51101	Өмч: - төрийн	497,040,067.31	497,040,067.31
512	Хуримтлагдсан үр дүн	348,884,304.34	293,706,219.28
51210	Өмнөх үеийн үр дүн	348,884,304.34	348,884,304.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	345,209,602.34	345,209,602.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,191,133,973.99</u>	<u>1,135,955,888.93</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,031,348,745.00	1,615,685,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,106,800.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	5,106,800.00	-

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,106,800.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,106,800.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,026,241,945.00	1,615,685,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	967,201,500.00	1,541,672,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	967,201,500.00	1,541,672,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,040,445.00	74,013,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,040,445.00	74,013,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,084,973,252.30	1,670,863,285.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,084,973,252.30	1,670,863,285.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,074,914,357.30	1,664,936,720.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	822,227,860.00	1,360,648,912.95
210101	Үндсэн цалин	574,656,949.00	775,888,945.00
210102	Нэмэгдэл	142,520,203.00	240,548,510.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	78,056,696.00	161,330,682.00
210104	Урамшуулал	26,994,012.00	182,880,775.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,976,354.00	169,050,229.07
210201	Тэтгэврийн даатгал	73,175,700.00	116,800,851.30
210202	Тэтгэмжийн даатгал	8,183,400.00	13,266,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,546,300.00	10,174,277.77
210204	Ажилгүйдлийн даатгал	1,637,100.00	2,275,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,433,854.00	26,532,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,788,482.00	19,952,076.87
210301	Гэрэл, цахилгаан	3,010,361.00	3,520,278.29
210302	Түлш, халаалт	9,178,243.00	13,187,979.27
210303	Цэвэр, бохир ус	2,599,878.00	3,243,819.31
2104	Хангамж, бараа материалын зардал	31,320,288.00	37,543,674.01
210401	Бичиг хэрэг	19,250,650.00	18,575,950.00
210402	Тээвэр, шатахуун	1,323,740.00	4,908,860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	437,524.00	1,863,105.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	321,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,692,274.00	1,051,220.00
210408	Бараа материал акталсны зардал	8,295,100.00	11,144,539.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,246,496.00	30,248,952.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,719,744.00	16,112,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,450,000.00	13,450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	452,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	147,252.00	157,952.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	266,000.00	529,000.00
210807	Газрын төлбөр	211,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,354,877.30	47,492,876.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	956,000.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,354,877.30	46,536,876.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,058,895.00	5,926,564.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,078,400.00	2,382,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,078,400.00	2,382,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	659,794.00	996,906.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	659,794.00	996,906.12
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,320,701.00	2,547,357.98
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,320,701.00	2,547,357.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(53,624,507.30)</u>	<u>(55,178,085.06)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(53,624,507.30)</u>	<u>(55,178,085.06)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,026,241,945.00</u>	<u>1,615,685,200.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,026,241,945.00</u>	<u>1,615,685,200.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	967,201,500.00	1,541,672,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	967,201,500.00	1,541,672,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,040,445.00	74,013,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,040,445.00	74,013,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,025,306,945.00</u>	<u>1,615,685,200.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,025,306,945.00</u>	<u>1,615,685,200.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>1,015,248,050.00</u>	<u>1,609,758,635.90</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	822,227,860.00	1,360,648,912.95
210101	Үндсэн цалин	574,656,949.00	775,888,945.00
210102	Нэмэгдэл	142,520,203.00	240,548,510.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	78,056,696.00	161,330,682.00
210104	Урамшуулал	26,994,012.00	182,880,775.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,976,354.00	169,050,229.07
210201	Тэтгэврийн даатгал	73,175,700.00	116,800,851.30
210202	Тэтгэмжийн даатгал	8,183,400.00	13,266,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,546,300.00	10,174,277.77
210204	Ажилгүйдлийн даатгал	1,637,100.00	2,275,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,433,854.00	26,532,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,788,482.00	19,952,076.87
210301	Гэрэл, цахилгаан	3,010,361.00	3,520,278.29
210302	Түлш, халаалт	9,178,243.00	13,187,979.27
210303	Цэвэр, бохир ус	2,599,878.00	3,243,819.31
2104	Хангамж, бараа материалын зардал	20,008,858.00	28,902,465.01

210401	Бичиг хэрэг	16,544,250.00	17,527,300.00
210402	Тээвэр, шатахуун	955,000.00	4,908,860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	437,524.00	1,863,105.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	321,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,751,084.00	4,603,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,246,496.00	30,248,952.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,719,744.00	16,112,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,450,000.00	13,450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	452,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	147,252.00	157,952.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	266,000.00	529,000.00
210807	Газрын төлбөр	211,500.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	956,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	956,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,058,895.00	5,926,564.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,078,400.00	2,382,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,078,400.00	2,382,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	659,794.00	996,906.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	659,794.00	996,906.12
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,320,701.00	2,547,357.98
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,320,701.00	2,547,357.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>935,000.00</u>	≡
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	935,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	935,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	935,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	935,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(935,000.00)</u>	≡
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-	497,040,067.31	345,209,602.34	402,508,811.64	1,244,758,481.29

	нээрх үлдэгдэл				
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	497,040,067.31	345,209,602.34	402,508,811.64	1,244,758,481.29
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(53,624,507.30)	(53,624,507.30)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	497,040,067.31	345,209,602.34	348,884,304.34	1,191,133,973.99
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	497,040,067.31	345,209,602.34	348,884,304.34	1,191,133,973.99
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	497,040,067.31	345,209,602.34	348,884,304.34	1,191,133,973.99
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(55,178,085.06)	(55,178,085.06)
D09	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	497,040,067.31	345,209,602.34	293,706,219.28	1,135,955,888.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тоо	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,541,672,200.00	1,539,581,476.65	(2,090,723.35)	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,541,672,200.00	1,539,581,476.65	(2,090,723.35)	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,539,289,900.00	1,537,199,176.65	(2,090,723.35)	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,326,645,800.00	1,326,368,405.00	(277,395.00)	100.0
210101	Үндсэн цалин	883,191,700.00	775,888,945.00	(107,302,755.00)	87.9
210102	Нэмэгдэл	322,724,800.00	240,548,510.00	(82,176,290.00)	74.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	69,476,700.00	161,330,682.00	91,853,982.00	232.2
210104	Урамшуулал	51,252,600.00	148,600,268.00	97,347,668.00	289.9

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,830,700.00	165,014,277.77	(816,422.23)	99.5
210201	Тэтгэврийн даатгал	112,764,900.00	112,764,900.00	-	100
210202	Тэтгэмжийн даатгал	13,266,400.00	13,266,400.00	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,613,200.00	10,174,277.77	(438,922.23)	95.9
210204	Ажилгүйдлийн даатгал	2,653,300.00	2,275,800.00	(377,500.00)	85.8
210205	Эрүүл мэндийн даатгал	26,532,900.00	26,532,900.00	-	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,920,300.00	19,952,076.87	(968,223.13)	95.4
210301	Гэрэл, цахилгаан	3,675,900.00	3,520,278.29	(155,621.71)	95.8
210302	Түлш, халаалт	13,594,100.00	13,187,979.27	(406,120.73)	97.0
210303	Цэвэр, бохир ус	3,650,300.00	3,243,819.31	(406,480.69)	88.9
2104	Хангамж, бараа материалын зардал	11,751,300.00	11,727,465.01	(23,834.99)	99.8
210401	Бичиг хэрэг	6,130,800.00	6,130,800.00	-	100
210402	Тээвэр, шатахуун	448,600.00	448,600.00	-	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,260,800.00	544,865.01	(715,934.99)	43.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,553,800.00	4,603,200.00	2,049,400.00	180.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,141,800.00	14,136,952.00	(4,848.00)	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,450,000.00	13,450,000.00	-	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,800.00	157,952.00	(4,848.00)	97.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	529,000.00	529,000.00	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2382300.00	2382300.00	-	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,382,300.00	2,382,300.00	-	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,382,300.00	2,382,300.00	-	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,541,672,200.00	1,539,581,476.65	(2,090,723.35)	99.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,541,672,200.00	1,539,581,476.65	(2,090,723.35)	99.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,541,672,200.00	1,539,581,476.65	(2,090,723.35)	99.8

132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	74	74	-	100
620001	Удирдах ажилтан	01	01	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	63	63	-	100
620003	Үйлчлэх ажилтан	10	10	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,559,459.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,559,459.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,559,459.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,280,507.95
210104	Урамшуулал	34,280,507.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,035,951.30
210201	Тэтгэврийн даатгал	4,035,951.30
2104	Хангамж, бараа материалын зардал	17,175,000.00
210401	Бичиг хэрэг	11,396,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,460,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,318,240.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,112,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,112,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	956,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	956,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	72,559,459.25
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	72,559,459.25
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,559,459.25

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,090.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Санхүүжилтийн эх үүсвэрийг 2,090.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. Энэ нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 5,401.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 5,401.5 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн дансны орлогоос худалдаж авсан 3,781.5 мянган төгрөгийн шатахууныг эд хариуцагчийн дансаар дамжуулан бүртгээгүй, шууд зарцуулсан байна. Энэ нь ажил гүйлгээ бүртгэлээс орхигдох, төсвийг хяналтгүй зарцуулах үр дагаврыг бий болгох, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар"-ын 4.21 *"Бараа материалыг (хангамжийн зүйлийг) худалдан авсан үед: Дт. Хангамжийн материал, Кт. Мөнгөн хөрөнгө / Дансны өглөг"* заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэлт санхүүжилтийн орлогоос худалдаж авсан шатахуун, бусад материал, хөрөнгийг анхан шатны баримтыг үндэслэн эд хариуцагчийн тайлангаар дамжуулан бүртгэж байх.

1. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны ажлын хөтчөөр ажилласан хороодын хэсгийн ахлагч нарт 1,620.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгож төсвийг хэмнэлтгүй зарцуулсан байна. Энэ нь төсөв хяналтгүй зарцуулагдах үр дагавар бий болгосон ба Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.2 *"батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"* заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Үйл ажиллагаандаа төрийн албан хаагчийг оролцуулбал төсвөөс давхардуулан цалин, урамшуулал олгохгүй, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар зарцуулж байх.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруула агүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнг илүү тайлагнасан	1	2,090.7			1	2,090.7	1	2,090.7				
Дүн	1	2,090.7	-	-	1	2,090.7	1	2,090.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нэмэлт санхүүжилтийн дансны орлогоос худалдаж авсан шатахууныг эд хариуцагчийн дансаар дамжуулан бүртгээгүй,	1	3,781.5					1	3,781.5				
Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны ажлын хөтчөөр ажилласан хороодын хэсгийн ахлагч нарт ажлын хөлс	1	1,620.0					1	1,620.0				

олгож төсвийг хэмнэлтгүй зарцуулсан байна.											
Дүн	2	5,401.5					2	5,401.5			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хэмнэлтийн горимд тохируулан ажиллах тоолуур ашиглаагүй	1	0					1	0
Үйл ажиллагаандаа ашиглаж байгаа “Старикс” маркын суудлын авто машины улсын дугаарыг цэнхэр дэвгэрээр солиогүй	1	0					1	0
Нийт дүн	2	0					2	0